БАТЛАВ
НИЙСЛЭЛИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

М.ЦОГЗОЛМАА

2026 оны 10 дугаар сарын 13

БАТЛАВ
МОНГОЛЫН УСАН СПОРТ СОНИРХОГЧДЫН ХОЛБООНЫ ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

М.ЭНХБААТАР

2026 оны 10 дугаар сарын 13

УДИРДАМЖ

2026 оны 10 дугаар сарын 08 Улаанбаатар хот

НИЙСЛЭЛИЙН “ХАНГАРДИ” СПОРТ НААДМЫН УСАНД СЭЛЭЛТИЙН НЭЭЛТТЭЙ ТЭМЦЭЭН

Нэг.Зорилго

1.1.Монгол Улсын Биеийн тамир, спортын тухай хууль, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх, Нийслэл Улаанбаатар хотын 387 жилийн ойн хүрээнд, Нийслэлийн өсвөр үе, залуучууд, насан хүрэгчдийг усан спортоор хичээллэхэд идэвх сонирхлыг дэмжих, иргэдийг спортын уралдаан тэмцээнд өргөнөөр хамруулж, хөдөлгөөний хомсдолоос сэргийлэх, биеийн дархлааг дэмжихэд тэмцээний зорилго оршино.

Хоёр.Тэмцээний зохион байгуулалт, хугацаа

2.1.Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн Биеийн тамир, спортын газар, Монголын Усан спорт сонирхочдын холбоо, Монголын мастерсийн усанд сэлэлтийн холбоотой хамтран зохион байгуулна.

2.2.“Хангарди” спорт наадмын усанд сэлэлтийн тэмцээнийг 2026 оны 11 дүгээр сарын 28-29-ний өдрүүдэд Сонгинохайрхан дүүргийн Биеийн тамир, спортын усан бассейнд зохион байгуулна.

Гурав.Ерөнхий мэдээлэл, насны ангилал

3.1.Усанд сэлэлтийн тэмцээн нь “МУССХ-ны тэмцээний дүрэм”-ийн дагуу явагдана.

3.2.Тэмцээнийг ур чадварын доорх ангилалд зохион байгуулна.

3.3.А ангилал (зэрэг цолтой тамирчид)

3.4.В ангилал (сонирхогч тамирчид)

3.5.С ангилал (эхлэн суралцагч буюу анх удаа тэмцээнд оролцож буй тамирчин) гэсэн ангилалд ганцаарчилсан болон багийн буухиа төрлөөр зохион байгуулна.

3.6.Ангилалд дэвшиж оролцож болно. Тамирчид нэг ангилалд оролцоно.

3.7.Багийн буухиа төрөлд ангилал хамаарахгүй оролцох боловч нэг буухиа багт 2-оос илүүгүй А ангилалын тамирчин оролцож болно.

3.8.Насны бүлэг: тус тэмцээнд 25-34 нас-(2001-1992 он), 35-44 нас-(1991-1982 он), 45-54 нас-(1981-1972 он), 55-64 нас-(1971-1962 он), 65+ нас-(1960 оноос өмнө) насны ангилалд нээлттэй оролцоно.

3.9.Буухиа тэмцээн өвөрөөр даллах, холимог сэлэлтээр зохион байгуулна. Буухиа насны бүлэг буюу багийн 4 гишүүний 2 эрэгтэй, 2 эмэгтэй тамирчин байна. Насны нийлбэр: 110-139 нас, 140-169 нас, 170-199 нас, 200+ нас

3.10.Насны бүлгийг 2026 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тоох бөгөөд тамирчид зөвхөн өөрийн насны бүлэгт өрсөлдөнө.

3.11.Тэмцээний төрөл зай,

3.12.Тэмцээний төрөл: (С-эхлэн суралцагч)

№	Зай, төрөл	25-34 нас	35-44 нас	45-54 нас	55-64 нас	65+
1.	25м өврөөр даллах	+	+	+	+	+
2.	25м мэлхий сэлэлт	+	+	+	+	+
3.	50м өврөөр даллах	+	+	+	+	+
4.	50м Мэлхий сэлэлт	+	+	+	+	+

3.13.Тэмцээний төрөл: (А-мэргэжлийн ангилал, В-сонирхогчдын ангилал)

№	Зай, төрөл	25-34 нас	35-44 нас	45-54 нас	55-64 нас	65+
1.	50м Өврөөр даллах	+	+	+	+	+
2.	50м Араар даллах	+	+	+	+	+
3.	50м Мэлхий сэлэлт	+	+	+	+	+
4.	50м Далайн гахай	+	+	+	+	+

3.14.Буухиа төрөл (4 гишүүний 2 эрэгтэй, 2 эмэгтэй тамирчин)

№	Зай, төрөл	110-139 нас,	140-169 нас,	170-199 нас,	200+ нас	
1.	4х50м Өврөөр даллах	+	+	+	+	

3.15.Холбогдох дугаар-88131777, 88113705

Дөрөв.Тэмцээний бүртгэл

4.1.Тэмцээнд уралдах төрөл/зай тус бүрт гарааны хураамж-10.000₮, татвар хураамжийг:450014950 тоот ХХБанк, Монголын Усан спорт сонирхогчдын холбоо, Утга: Тамирчны нэрийг бичих.

4.2.Тэмцээний бүртгэлийн маягтыг 2026 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн 23:59 цагаас өмнө доорхи мэйлээр илгээсэн байна.

4.3.Гарааны хураамжаа төлж, мэдүүлгээ тогтоосон хугацаанд гаргасан, Улаанбаатар хотод оршин суугч бүх тамирчид тэмцээнд оролцох эрхтэй.

4.4.Бүртгэлийн маягтыг: www.mongoliaaquatics.mn сайтын <Тэмцээний хуваарь> цэснээс <"Хангарди"-ын усанд сэлэлтийн тэмцээн >-ийг сонгож ороод, <Протокол татах> гэсэн хэсгээс татан авна. office@mongoliaaquatics.mn мэйл рүү тогтоосон хугацаанаас өмнө мэдүүлгийн маягтыг латин үсэг ашиглан үнэн зөв бөглөөд илгээнэ.

4.5.Бүртгэлийн маягтыг бөглөх заавар:

Masters Swimm	Uvurkhangai	Mongolia	SCM	06/08-09/2024				
NATION	**CLUBNAME**	**FIRSTNAME**	**LASTNAME**	**GENDER**	**BIRTHDATE**	**STROKE**	**DISTANCE**	**ENTRYTIME**
MGL	Vista	Uuganbayar	Chuhal	M	4/22/1970	Free	100	1:20.35
MGL	Vista	Uuganbayar	Chuhal	M	4/22/1970	Breast	50	57.12
MGL	Vista	Uuganbayar	Chuhal	M	4/22/1970	Fly	200	4:01.15
MGL	Khilem	Nasanbat	Sugar	F	12/18/1985	Back	50	59.65
MGL	Khilem	Nasanbat	Sugar	F	12/18/1985	Medley	100	2:12.85
MGL	Khilem	Nasanbat	Sugar	F	12/18/1985	Free	200	3:23.46
MGL	**Клубын нэр**	**Нэр**	**Овог**	**Хүйс**	**сар/өдөр/он**	**Сэлэлт төрөл**	**Зай**	**Мин : Сек . Доль**

4.6.Техникийн зөвөлгөөнд бүх багийн ахлагчид оролцох үүрэгтэй бөгөөд хүндэтгэх шалтгаангүйгээр оролцоогүй багийн ахлагчид 100'000 төгрөгийн торгууль ноогдуулна.

4.7.Тэмцээнд оролцогчдын мэдээллийг тэмцээн эхлэхээс 5 хоногийн өмнө Splashme апп-д нийтэлнэ.

4.8.Багийн ахлагч нар гарааны хуваарь гарсны дараа өөрийн багийн тамирчдын бүртгэлийг нягтлан шалгаж, ямар нэг алдаа гарсан байвал яаралтай зохион байгуулагчдад мэдэгдэх үүрэгтэй.

4.9.Тамирчид тэмцээнд оролцохын өмнө хувийн аюулгүй байдал, хариуцлагын журам, заавартай танилцаж гарын үсэг зурснаар тэмцээнд оролцох эрх эцсийн байдлаар нээгдэнэ (12 дугаар хуудас, хэвлэж гарын үсэг зурах). Багийн ахлагчид тамирчдынхаа гарын үсэг зурсан хуудсыг нэгтгэж авах үүрэгтэй бөгөөд тэмцээнийг зохион байгуулагчдыг шаардах үед бэлэн байлгана.

Тав.Буцаалт

5.1.Эрүүл мэндийн шалтгаанаас бусад тохиолдолд тамирчин гараанд гараагүй бол тамирчныг 50,000 төгрөгөөр торгоно.

5.2.Эрүүл мэндийн шалтгаанаар гараанд гараагүй тамирчин тухайн өдрийн бусад гараанд оролцох эрхгүй.

5.3.Багийн ахлагч гараанд гараагүй тамирчны маягтыг бөглөж, эрүүл мэндийн магадлагааны хамт гараа эхлэхээс 30 минутаас багагүй хугацааны өмнө Ерөнхий шүүгчид хүргүүлсэн байна.

5.4.Тэмцээнийг зохион байгуулагчдын буруутай үйлдлээс болж баг/тамирчин ямар нэг алдаа гаргаж шийтгэл хүлээсэн нь тогтоогдвол баг/тамирчны шийтгэлийг нэн даруй хүчингүй болгож амжилтыг сэргээж, цаашид тэмцээнээ үргэлжлүүлэх боломжоор хангана.

Зургаа.Шагнал, урамшуулал

6.1.Усанд сэлэлтийн тамирчид/багууд ижил цагийн амжилт үзүүлсэн бол медалийг доорх байдлаар олгоно.

6.2.Усанд сэлэлтийн нэгдүгээр байрны тамирчдын цаг ижил бол: (2 алт, мөнгө байхгүй, 1 хүрэл)

6.3.Усанд сэлэлтийн хоёрдугаар байрны тамирчдын цаг ижил бол: (1 алт, 2 мөнгө, хүрэл байхгүй)

6.4.Усанд сэлэлтийн гуравдугаар байрны тамирчдын цаг ижил бол: (1 алт, 1 мөнгө, 2 хүрэл)

6.5.Усанд сэлэлтийн хэрэв гурван (3) тамирчин ижил цагийн амжилт гаргасан бол медалийг доорх байдлаар олгоно.

6.6.Усанд сэлэлтийн нэгдүгээр байрны тамирчдын цаг ижил бол: (3 алт, мөнгө, хүрэл байхгүй)

6.7.Насны ангилал бүрийн эхний гурван байрыг нийт зай, төрөл бүрийн нийлбэр оноогоор нэгтгэж мөнгөн шагнал олгоно.

6.8.Усанд сэлэлтийн багийн дүнг дараах онооны системээр үнэлж, хамгийн өндөр оноо авсан багт алт, мөнгө , хүрэл медаль, цомоор шагнана. (Хувийн гараа, байр 1-3, 6, 4, 2 оноо)

6.9.Байгууллагын дүнг гаргахдаа оролцсон зай төрөл бүрт 1-р байр-5 оноо, 2-р байр-4 оноо, 3-р байр-3 оноо 4-р байр-2 оноо, 5-р байр-1 оноо, оролцоо 0,5 оноо нэгтгэж байр эзлүүлнэ.

Долоо.Бие халаалтын заавар

7.1.Тэмцээн эхлэхээс 90 минутын өмнө тамирчдын бие халаалт эхлэнэ.

7.2.Бие халаалтын журмын биелэлтийг Ерөнхий шүүгч хянаж ажиллана.

7.3.Баг тамирчид зөвхөн зохион байгуулагчдын гаргасан хуваарийн дагуу халаалтаа хийх бөгөөд багийн ахлагчид хяналт тавих үүрэгтэй.

7.4.Тамирчид усан сангийн ирмэг дээр суусан байрлалаас хөлөөрөө ус руу орно. Ус руу үсэрч орохыг хатуу хориглоно.

7.5.Бие халаалтын үндсэн замуудыг доорхи зурагт үзүүлсний дагуу тойрог хэлбэрээр хоёр чиглэлд сэлэхэд ашиглах бөгөөд тус замд шумбалт хийхийг хориглоно.

7.6.Хурдтай сэлэлтийн болон араар даллах сэлэлтийн замыг зөвхөн нэг чиглэлд ашиглах бөгөөд зөвхөн энэ замд шумбалт хийхийг зөвшөөрнө.


7.7.Бие халалтын үед сэлүүр ашиглахыг хориглоно.

7.8.Дасгалжуулагчид бие халаалтын журам болон аюулгүй байдлын зааварчилгааг тамирчиддаа өгөх үүрэгтэй бөгөөд бие халаалтын үеэр байнга хамт байж аюулгүй байдалд нь хяналт тавина. Бусад багуудын халаалтын цаг болоход тамирчдаа усан сангаас даруй гаргах үүрэгтэй.

7.9.Автомат цагийн мэдрэгч хавтан суурьлуулсан талаар усан сангаас гарах тамирчид зөвхөн хажуу талын хананы дагуу усан сангаас гарна.

7.10.Бие халаалтын журам зөрчсөн тамирчныг Ерөнхий шүүгч болон тэмцээний зохион байгуулагчид усан сангаас нэн даруй гаргана.

7.11.Тэмцээн эхлэхээс 15 минутын өмнө усан бассейныг чөлөөлнө.



Найм.Эсэргүүцэл

8.1.Эсэргүүцэл илэрхийлэх боломжтой.

8.2.Эсэргүүцлийг доорхи тохиолдолд гаргаж болно.

8.2.1.Тэмцээний дүрэм, зохион байгуулах журам тодорхой биш

8.2.2.Тамирчдад ямар нэг эрсдэл үүссэн бол

8.2.3.Шүүгчийн шийдвэрийг эсэргүүцэж болно.Гэвч баримтад тулгуурласан шийдвэрийг эсэргүүцэхийг хориглоно.

8.3.Эсэргүүцэл мэдүүлэхдээ дараах зүйлсийг анхаарна. Үүнд:

8.3.1.Ерөнхий шүүгчид мэдүүлэх

8.3.2.Холбооноос боловсруулсан маягтан дээр эсэргүүцлийг бичсэн байх

8.3.4.Багийн ахлагч мэдүүлгийг бөглөх

8.3.5.50,000 төгрөгийн хураамж төлсөн байх (МУССХ-ны дансанд, шилжүүлгийн баримтыг үзүүлэх)

8.3.6.Тухайн уралдаан болсноос хойш 30 минутын дотор дүрмийн дагуу мэдүүлсэн эсэргүүцлийг дараагийн үйл ажиллагаа болон тэмцээний гараа эхлэхээс өмнө шийдвэрлэнэ.

8.4.Бүх эсэргүүцлийг Ерөнхий шүүгч хянаж шийдвэрлэнэ.Ерөнхий шүүгч эсэргүүцлийг хүлээж авахгүй байх шийдвэр гаргасан бол шалтгааныг тайлбарлах үүрэгтэй.

8.5.Эсэргүүцлийг хүлээж авахгүй байх шийдвэр гарсан бол 9.3.5 заасан хураамжийг буцаан олгохгүй. Эсэргүүцлийг хүлээн авсан бол хураамжийг буцааж олгоно.

Ес.Тэмцээний хувцас, хэрэглэл, сурталчилгаа

9.1.Усанд сэлэлтийн тэмцээний эрэгтэй усны хувцасны дээд хэсэг хүйснээс дээш, доод хэсэг өвдөгнөөс доош байж болохгүй. Эмэгтэйчүүдийн хувьд усны хувцас нь хүзүүг халхалж, дээд хэсэг мөрнөөс дээш, доод хэсэг өвдөгнөөс доош байж болохгүй. Усны хувцас нь нэхмэл материалаар хийгдсэн байх ёстой.

9.2.Усны өмсгөлийн өнгө тунгалаг/гэрэлтэж харагддаг байж болохгүй. 2 \Хоёр\ давхар малгай өмсч болно.

9.3.Тамирчны малгай, шил нь усан сэлэлтийн төрөлд тохирсон байх бөгөөд ямар нэгэн сөрөг сэтгэгдэл төрүүлэх тэмдэг, тэмдэглэгээгүй байна.

9.4.Тэмцээний үеэр тамирчин хурд, хөвөх чадвар, тэсвэр хатуужилд нь туслах ямар нэгэн төхөөрөмж, усны хувцас ашиглахыг хориглоно.

9.5.Гэмтлийн улмаас хоёроос илүүгүй хөлийн хурууг нааж болно. Ерөнхий шүүгч зөвшөөрснөөс бусад тохиолдолд тамирчин бие дээрээ ямар нэг наалт наахыг хориглоно.

9.6.Өсвөр үе, залуучуудын насны бүлгийн рекорд амжилтыг зөвшөөрөгдсөн усан сэлэлтийн хувцас хэрэглэсэн тохиолдолд л МУССХ хүлээн зөвшөөрнө.

9.7.Тамирчид тэмцээний нээлт, хаалт, шагнал гардуулах ёслолын үеэр багийн бэлтгэлийн хувцаар жигдэрсэн байна.

9.8.Тамхи болон согтууруулах ундааны сурталчилгааг хориглоно.

9.9.Бие дээрх ямар нэг таних тэмдэг, сурталчилгааг хориглоно.

9.10.Тамирчны харьяалагдах байгууллага, клубын нэр болон таних тэмдгийг зар сурталчилгаанд тооцохгүй.

9.11.Энэхүү дүрмийн ерөнхий шаардлагыг илт зөрчсөн хувцас хэрэглэлтэй тамирчинд Ерөнхий шүүгч зөрчлийг арилгах шаардлага тавих бөгөөд шаардлагыг биелүүлээгүй бол тэмцээнээс хасах эрхтэй.

Арав.Тэмцээнд оролцогчдын ёс зүйн хэм, хэмээ

10.1.Тэмцээнд оролцогч тамирчид, дасгалжуулагчид, баг хамт олон, эцэг эхчүүд болон хөгжөөн дэмжигчид доорхи ёс зүйн хэм хэмжээг баримтлана. Үүнд:

10.2.Үнэнч шударгаар өрсөлдөж, ёс зүйн аливаа зөрчил гаргахаас зайлсхийх

10.3.Усан спортыг гутаан доромжлох, усан спорт болон МУССХ-ны нэр хүндийг унагаах үйлдэл/ эс үйлдэл хийхээс зайлсхийх.

10.4.Тэмцээнийг зохион байгуулагчид болон бусад тамирчид, хэвлэл мэдээлэл болон үзэгчдийн эсрэг заналхийлсэн, хүчирхийлсэн, үл хүндэтгэсэн зан авир гаргахгүй байх.

10.5.Бусдыг үндэс угсаа, арьсны өнгө, нас хүйс, шашин шүтлэг, хэл соёл, хувийн үзэл бодол, өмч хөрөнгө, хөгжлийн бэрхшээл болон бусад бүх үндэслэлээр ялгаварлан гадуурхахаас зайлсхийх.

10.6.Тэмцээний үйл ажиллагаа, зохион байгуулалтад саад учруулах, хөндлөнгөөс оролцох, тогтоосон дэгийг зөрчихгүй байх. Энэ заалт нь усан сангийн бүх хэсэг болон тухайн арга хэмжээний гадна талбайд болсон зөрчилд ч хамаарна.

10.7.Тэмцээний бүхий л үйл ажиллагаа буюу нээлт, хаалт, шагнал гардуулах ёслолд идэвхтэй оролцох.

10.8.Сэргээшийн эсрэг хөтөлбөрийг дэмжиж, дэлхийн сэргээшийн эсрэг дүрмээр хориглосон ямар нэг бэлдмэл, зан үйлийг ашиглахгүй байх.

10.9.Согтууруулах ундаа, утаат болон цахилгаан тамхи (vape) хэрэглэхийг хатуу хориглоно. Энэ заалт нь усан сангийн бүх хэсэг болон тухайн арга хэмжээний гадна талбайд болсон зөрчилд ч хамаарна.

10.10.Тамирчдын насыг санаатайгаар буруу мэдээлэх, холбогдох баримтыг засварлах, хуурамчаар үйлдэхгүй байх.

10.11.Эдгээр ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн аливаа үйлдэл/эс үйлдлийг тэмцээнийг зохион байгуулах хороонд мэдэгдэж хамтран ажиллах.

Арван нэг.Тамирчны харьяалал, дүүргээ төлөөлөх эрх

11.1.Тамирчин нь тухайн байгууллага, клубын гишүүн боловч 14.1-д заасан шаардлагыг хангаагүй тохиолдолд тэмцээнд оролцох эрхгүй.

11.2.Харьяаллын дүрмийг зөрчсөн тохиолдолд МУССХ-ны дүрэм, Ёс зүйн дүрмийн дагуу шалгалтын ажиллагаа явуулж, хянан шийдвэрлэх эрхийг МУССХ-ны Ёс зүйн зөвлөл эдлэнэ.

11.3.Ёс зүйн зөвлөл нь Ёс зүйн дүрмэнд заасны дагуу зөрчилд тохирох шийтгэлийг ноогдуулахаас гадна тухайн тамирчны тухайн тэмцээнд оролцох эрхийг хасах боломжтой. Тамирчны харьяаллын дүрмийг зөрчиж оролцсон тэмцээний бүх шагнал, медаль, оноо, цолыг хураана.

НИЙСЛЭЛИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗАР
МОНГОЛЫН УСАН СПОРТ СОНИРХОГЧДЫН ХОЛБОО